МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,092,331... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.07.04. Даваа. №133 (4503) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

Ц.ЭЛБЭГДОРЖ: НАЙМДУГААР САРЫН 1 ГЭХЭД УИХ, ЗАСГИЙН ГАЗАР БҮРДЭХ ЁСТОЙ ШҮҮ

II нүүрт

ДЭЛХИЙ

БАНГЛАДЕШИЙН “ХАР БААСАН ГАРАГ”

VI нүүрт

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

# ТӨР ТҮШИХ

## 76 эрхэм түр үнэмлэхээ гардаж авлаа




*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Үргэлжлэл нь II нүүрт

Дугаарын 60 мөр

## МАН-ынхаан хэлсэндээ хүрээрэй

Э. ТУУЛ

Шинэ УИХ анхны чуулганаа хийж, Ерөнхий сайдаа томилсны дараа л Засгийн газар байгуулах яриа өрнөх учиртай. Гэвч МАН-ынхан аль хэдийнэ хэн хаана очихоо яриад эхэлчихсэн сурагтай. Эргэн сануулвал, МАН-ынхан мөрийн хөтөлбөртөө “Мэргэжлийн Засгийн газар” байгуулж ажиллах, богино хугацаанд эдийн засгийг тогтворжуулна гэсэн заалтыг тусгасан. Мөн үндсэн чиг үүргийн таван яамнаас бусад яамыг давхар дээлгүй буюу УИХ-ын гишүүн бус хүмүүсийг сонгоно. Өөрөөр хэлбэл, сайд нар дан дээлтэй байхаас гадна, яг тухайн салбарынхаа мэргэжилтэн нь байх ёстой гэдгийг онцолсон билээ. Тэгвэл МАН 2016 оны УИХ-ын сонгуульд 65 суудал авч, үнэмлэхүй ялалт байгуулчихлаа. Ингэснээр ямар нэг улс төрийн нам хүчинтэй эвсэхгүй дангаараа Засгийн газар бүрдүүлж ажиллах эрхзүйн орчин бүрдээд байгаа юм.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## ХЯТАДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ КОМПАНИ МОНГОЛЫН СОНГУУЛИЙГ ШИЙДЭЖ БАЙНА

2004 оноос хойш 2005, 2008, 2009, 2012, 2013, 2016 гээд олон сонгуульд нэр дэвшсэн, ажилласан миний хувьд 2016 оны УИХ, аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгууль “ер бусын” болж өнгөрлөө. Сонгуулийн сурталчилгааны явцад хэт улс төржих, намууд нэгнийгээ газар доогуур ортол муулах, санал авахын тулд яахаас ч буцахаа больж улайрах, элдэв арга сэдэх, санал илүү дутуу тооллоо гэж маргалдах зэрэг бол байдаг л ердийн үзэгдэл. Царцааны нүүдэл ч шинэ юм биш. Тэгвэл яагаад, юугаараа ер бусын болов? гэж асуух байх. Энэ нь нэг үгээр тайлбарлахад түвэгтэй асуудал учраас тогтож ярьцгаая.

### Улс төрийн тэмцэл дотоодын асуудал биш болсон

2016 оны сонгууль намуудын хооронд бус Ардчилсан нам ба нам дамнасан бүлэг, тэдний ард нуугдаж байгаа гадны хөрөнгө оруулалтын хооронд өрнөлөө гэдгээс эхлэе.

Царцааны нүүдэл гэх бохир аргачлалыг улс төрийн нам бус гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд ашиглаж, монгол төрийг сонгох явцыг будлиантуулсанд анхаарлаа хандуулах шаардлага тулгарч байгааг би хэлэх гээд байгаа юм. MCS групп өөрийн харьяа охин компаниудаас 7000 ажилтныг дайчлан компанид нь хамаарал бүхий нэр дэвшигчдийг дэмжүүлэхээр Хөвсгөл, Баянхонгор, Увс аймгууд руу түр шилжүүлсэн нь маш олон баримтаар нотлогдсоор байна. Увсын 31 дүгээр тойрогт (2778), Хөвсгөлийн 39 дүгээр тойрогт (2400), Баянхонгорын 9 дүгээр тойрогт (1913) шилжин санал өгөгсөд орон нутгийн иргэдийн өмнөөс шийдвэр гаргаж, нутгийнхан 4 жил “өөрсдийн бус” төлөөллийг УИХ-д суулгах ёстой болж таарав.

Үргэлжлэл нь V нүүрт

ӨӨР ӨНЦӨГ

## Э.БАТ-ҮҮЛИЙГ ХОТЫН ДАРГА БОЛГОЁ



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Э.ТУУЛ

Нийслэл хэмээх их айл биднийг нэг хаяг, нэг зүрх сэтгэлтэй болгодог. Угаасаа нийслэлд төрсөн өссөн, нүүж ирсэн хүн бүхэн л нийслэлийн иргэн. Тэд сайхан хотод амьдрахыг хүсч л энд ирсэн нь мэдээж. Тэгвэл нийслэл өмнө нь ямар байлаа даа. Хүн бүхэн надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа. Гэтэл өнгөрсөн дөрвөн жилд ямар өөрчлөлт оров. Дахиад нэг бодоод үзье. Хамгийн түрүүнд хамаг амьтны үсийг өрвийлгөж, стресстүүлдэг байсан замын түгжрэл. Гэртээ харих гэж 2-3 цаг түгжирч, түүндээ бухимдан стресстэж, түүнийгээ гэр орныхондоо гаргадаг байсан нь бодит үнэн. Тэгвэл дугаарын хязгаарлалт хийж, маш олон жижиг гүүрэн гарц, шинээр зам гаргаснаар өнөөдөр бид таг түгжирч, үхтлээ уурлан бухимдахаа больсон.

Үргэлжлэл нь III нүүрт




**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1980.00 | 1998.00 | ФУНТ | 2589.00 | 2680.00 |
| ЕВРО | 2174.00 | 2236.00 | РУБЛЬ | 29.00 | 33.10 |
| ИЕН | 19.06 | 19.64 | ЮАНЬ | 295.50 | 301.50 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1977.00 | 1998.00 | ФУНТ | 2578.00 | 2711.00 |
| ЕВРО | 2155.00 | 2265.00 | РУБЛЬ | 28.90 | 34.10 |
| ИЕН | 18.88 | 19.97 | ЮАНЬ | 295.30 | 302.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

# ТӨР ТҮШИХ 76 ЭРХЭМ ТҮР ҮНЭМЛЭХЭЭ ГАРДАЖ АВЛАА

Б.ТОГТОХ
Ж.ОТГОН

*УИХ-ын гишүүнээр сонгогдсон нэр дэвшигчдэд СЕХ-оос гишүүний түр үнэмлэхийг өнгөрөгч баасан гарагт гардууллаа. Энэ үеэр зарим гишүүний сэтгэгдлийг сонссон юм. УИХ-ын шинэ гишүүд энэ сарын 5-ны 11.00 цагт тангаргаа өргөснөөр УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь эхлэх билээ.*



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Д.Эрдэнэбат: МАН-ын мөрийн хөтөлбөрийг өдөр бүр сануулж ажиллана


*/Сэлэнгэ аймгаас УИХ-д нэр дэвшич сонгогдсон/*

-Сонгуулийн үр дүн бидэнд дүгнэлт хийх их зүйл байгааг сануууллаа. АН-ыг зайлшгүй шинэчлэх шаардлагатай гэдгийг ойлгож байгаа учраас намын даргадаа хурлаа яаралтай хийж намаа шинэчлэх цаг болжээ гэдгийг хэлнэ. АН нийт иргэдийн 50 хувийн саналыг авсан. Үүнийг дандаа санаж явах хэрэгтэй. Энэ удаагийн сонгууль мажоритар системээр явсан. 1996 оны салхи л дахин эргэж байна. Үнэмлэхүй олонхи болсон эрх баригчдад нэг зүйлийг дахин сануулъя. Ард түмний 50 хувийн санал ардчилагчдын талд байгаа шүү. Үүнийг өдөр бүр санаж яваарай. Бид УИХ-д есөн хүний бүрэлдэхүүнтэй болж байх шиг байна. Энэ бүлэг маргаашаас эхлэн МАН-ын мөрийн хөтөлбөрийг өдөр бүр сануулна. Энэ бол бидний хамгийн гол ажил.

## Ц.Цогзолмаа: Эхчүүд, хүүхдүүдийн төлөө 13 эмэгтэй гишүүн тууштай ажиллана



*/Сүхбаатар дүүргээс УИХ-ын гишүүнээр сонгогдсон/*

-УИХ-ын 62 дугаар тойрог буюу Сүхбаатар, Багануур дүүргийн иргэдийнхээ саналыг авч УИХ-ын гишүүнээр сонгогдож байгаадаа туйлын их баяртай байна. Нөгөө талдаа ард түмний энэ том итгэлд ямар зүтгэлээр хариу өгөх вэ гэдэг хамгийн чухал. Сонгуулийн сурталчилгааны үеэр иргэдтэйгээ уулзаж, амьдрал ахуйтай нь танилцаад явж байсан шигээ дөрвөн жилийн турш иргэдтэйгээ ойрхон ажиллана. Ялангуяа миний сонгогдсон тойрог бол дандаа гэр хороолол. МАН-ын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ иргэдийн өмнө тулгамдаж буй цэвэр усны хангамж, гэрэлтүүлэг, замын асуудлыг шийднэ. Нийслэлийн төвийн гудамжийн замыг хийсэн атлаа гэр хорооллын дундах замыг тэр чигээр нь орхисон. Нийслэлд амьдарч байгаа атлаа тоггүй байгаа асуудлыг шийдэх ёстой. Би НАМЭХ-ны Ерөнхийлөгчийн хувиар МАН-аас анх удаа 12 эмэгтэй УИХ-д сонгогдсонд баяртай байгаа. Энэ бол түүхэн амжилт. Тиймээс хүүхэд, эмэгтэйчүүд, өрх толгойлсон ганц бие эцэг, эхчүүдийн асуудлаар бид тууштай ажиллах болно.

## С.Жавхлан: Би нэг өдөр ч зүгээр суухгүй

*/Баянзүрх дүүргээс УИХ-ын гишүүнээр сонгогдсон/*

-Монголын тал нутаг, хамаг



Монголд хүртэл дэлхийгээр цацсан шагай шиг байгаа ах дүүс маань хүртэл чих тавин сонсч, намайг дэмжиж байлаа. Зөвхөн монголчууд биш. Хамаг монголчууд минь сонсч байлаа гэж хэлмээр байна. Надад итгэл хүлээлгэсэн тойргийн нийт түмэн олондоо маш их баярлалаа. Монгол дээлтэйгээ очиж, монгол сонгууль өгсөн бүх хүмүүстээ баярлалаа. С.Жавхлан ялаагүй. Монгол яллаа. Миний ярьж явдаг монгол ёс заншил яллаа. Мартагдаж байгаа соёл маань яллаа гэж хэлмээр байна. Энэ ялалт дахин олон зүйлийг ялах байх. Монголд асар их талцал үүсээд байна. Уулын ар, өврөөр нам, эвсэл, цэнхэр, улаанаараа талцаж байна. Тиймээс энэ муухай талцлыг оёж, эвцэлдүүлэх чиглэлийг барьж, ажиллах болно. Монголын төлөө бол бүгдтэй нь хамтарна. Ганцхан би ч биш бүгдийг нь дээл өмсгөнө. Монголын төлөө ярьж хуралдаж байгаа л бол монгол ёс заншлаараа байх ёстой. Өөрөө гадаад хувцас өмсч, гадаадаас хөрөнгө оруулдаг атлаа Монголын эдийн засаг гэж ярихгүй ээ. Одоо жинхэнэ ядаргаа болно. Танай ярилцлагыг уншиж байгаа бол улстөрчид өө бүгдээрээ дээлээ өмсөнө өө гэж хэлье. Тангараг өргөх ёслол, цаашлаад хуралдаа ч монгол хувцсаа өмсөхгүй бол С.Жавхлан тэмцэнэ шүү. Би УИХ-д суугаад зүгээр суухгүй. Суусан цэцнээс явсан тэнэг дээр гэдэг дээ. Ард түмнийхээ дунд явж ажиллана. Уран бүтээлээ ч орхихгүй.

## О.Баасанхүү: Ардчиллыг хамгаалахын төлөө тууштай явна



*/Орхон аймгаас УИХ-ын гишүүнээр сонгогдсон/*

-МАХН-аас нэр дэвшч сонгогдсоны хувьд намын дуу хоолойг хүргэнэ. Ардчилалд аюул учирсан. Энэ нь АН-ын лидер гэгдэх зарим этгээдүүдийн хоорондын зөрчлөөс хамаарч байна. Сонгуулийн үеэр иргэдийн санал их савлалаа. Тиймээс ардчиллыг хамгаалахын төлөө тууштай явна. Ардчилсан намыг хамгаална гэдгийг хариуцлагатайгаар хэлье. Харин МАН-ыг зөвд нь дэмжиж, бурууг нь шүүмжилж ажиллана.

## А.Сүхбат: Төрийг дампуурлаас гаргах ёстой


*/Төв аймгаас УИХ-д нэр дэвшин сонгогдсон/*

-Хамгийн том зорилго бол төрийг дампуурлаас гаргах. Ард түмнийхээ амьдарлыг дээшлүүлэх байна. Ер нь гэр хорооллын ард иргэдийн амьдрал хэцүү байна шүү дээ. Энэ хэцүү байдлыг яаж засч залруулах вэ л гэдэг байна. Хэцүү цаг үеийг яаж хамтдаа даван гарах эсэх талаар бодож байгаа. Манай намын мөрийн хөтөлбөр хүний амьдралын бүх мөчлөгт нийцсэн мөрийн хөтөлбөрийг дэвшүүлсэн. Амьдралд буусан, бүрэн хэрэгжих боломжтой мөрийн хөтөлбөр юм. Хэрэгжүүлэхийн төлөө бид хамтран ажиллах болно. Наадамдаа бэлдэн таван хүүхдийн бэлтгэл хийлгэж, бэлтгэлийг нь хангаж байгаа. Харин би наадамд зодоглохгүй. Одоо би чинь багш хүн шүү дээ.

## Н.Учрал: Түмэн олныхоо төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэнэ


*/Сонгинохайрхан дүүргээс УИХ-ын гишүүнээр сонгогдсон/*

-Сонгинохайрхан дүүргийн 72 дугаар тойрогт намайг дэмжиж, итгэл хүлээлгэсэн нийт сонгогчиддоо талархал илэрхийлье. Та бүгдийнхээ итгэлийг дааж, ярьснаа биелүүлэхийн зэрэгцээ намынхаа мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн тус дүүргийн таван хорооны асуудлыг шийдвэрлэж, түмэн олныхоо төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэнэ. Мөн сонгуулийн үеэр намайг дэмжээгүй сонгогчид байгаа. Цаашид тэдгээр хүмүүсийнхээ итгэлийг олж авахын төлөө ажиллана.

## Н. Амарзаяа: Ард түмэн яллаа


*/Өмнөговь аймгаас УИХ-ын гишүүнээр сонгогдсон/*

-СЕХ-ны тогтоол шийдвэрийн дагуу миний бие УИХ-ын гишүүний түр үнэмлэхээ гардлаа. Ард түмэн ялж, сонголт нь мэргэн байв. Ард түмнийхээ сонголтыг хүндэтгэж байна. Миний хувьд аймаг, орон нутгаа хөгжүүлэх, Монгол Улсын хууль тогтоох байгууллагын бодлого шийдвэрт ард түмний төлөөлөл болж сууж байгаа нь маш өндөр үүрэг хариуцлага гэж бодож байна. Ард түмэн дотроо ойр байсан миний хувьд орон нутгийнхаа хөгжлийн төлөө хоёргүй сэтгэлээр ажиллана. Өмнөговь аймгийн хувьд мэдээж тулгамдсан асуудал их бий. Байгалийн баялаг, ашигт малтмал ихтэй, Монгол Улсын хэмжээний томоохон үүц газар. Гэвч иргэдийн амьдрал хүнд хэцүү байгаа учраас тэр талаар илүүтэй анхаарч ажиллана. МАН-ынхан үнэмлэхүй олонхи бүрдүүлснээр мөрийн хөтөлбөр маань 100 хувь хэрэгжих боломж бүрдлээ. МАН-ын мөрийн хөтөлбөр хүн төвтэй байдаг. Нийгмийн чиглэлд илүү анхаарсан учраас миний хувьд ч гэсэн мөрийн хөтөлбөр нэг бүрийн заалтыг нутгийнхаа хөрсөнд буулгаж, хүүхэд, залуус, эхчүүд, ахмадуудынхаа төлөө ажиллах болно. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээ ч бид анхаарч ажиллах учиртай. Иргэд манай намын мөрийн хөтөлбөрийг санал нэг дэмжиж, багаар нь ялуулсан явдалд талархаж байна.

## Г.Мөнхцэцэг: Утга зохиолын салбарыг хөгжүүлнэ



*/Говьсүмбэр аймгаас УИХ-ын гишүүнээр сонгогдсон/*

-12 дугаар тойрог бол хоёр аймгийн 11 сумыг хамарсан маш том тойрог. Энэ удаа ард түмэн маань итгэл хүлээлгэж, асар их хариуцлага үүрүүллээ. Итгэл даахуйц төрийн төлөөлөл байж, эрч хүчтэй ажиллах болно. Мөн миний ажиллаж ирсэн утга зохиолын салбар сүүлийн жилүүдэд унаж босч явна. Тиймээс салбарынхаа хөгжлийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэнэ. МАН-ын мөрийн хөтөлбөр бүрэн хэрэгжинэ. Говьсүмбэр аймагт сургууль, цэцэрлэг, эмнэлгийн асуудал хүндрэлтэй байдаг. Үүнийг нь намынхаа мөрийн хөтөлбөрөөр дамжуулж өөрчилнө. Говьсүмбэр аймагт монгол түмний соёлын салбарын гал голомт болж байсан Боржигон чуулга байдаг. Тэгвэл эргээд энэ чуулгыг хөгжүүлэх, өөрийн гэсэн орон байртай болгох талаар ажиллана гэж бодож байна.

Шударга, Шуурхай, Оншгой мэдээлэл
minfo.mn

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

**Ерөнхий эрхлэгч:**
**С.ГАНТОГОО**

**Орлогч эрхлэгч**
**Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**
**99189158**

**Хариуцлагатай нарийн бичгийн дарга:**
**Э.ЭНХЦЭЦЭГ**
**88873012**

**Ахлах редактор:**
**Б.ӨНӨРТОГТОХ**
**88006842**

**Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба**
**Н.ПУНЦАГБОЛД**
**88096454**

**Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:**
**Б.ӨНӨРТОГТОХ**
**88006842**

**Гэрэл зургийн алба:**
**Г.АРГУУЖИН**
**96017873**

**Компьютерийн алба:**
**Б.ГАНЗОРИГ**
**99998796**

**Маркетинг, зар сурталчилгааны алба:**
**Н.АЛТАНЦЭЦЭГ**
**99173710**

**Захиалга, борлуулалтын алба:**
**М.ДАВААДУЛАМ**
**99042510**

**Э.САЙНЗАЯА**
**99197866**

**Дугаарыг эрхэлсэн**
**Э.ЭНХЦЭЦЭГ**

*Улсын бүртгэлийн дугаар: 907300528*
*Индекс: 100757*

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.**
**2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс:**
**976-70113551**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Анхдугаар хуралдааныг Ч.Улаан гишүүн даргална гэв

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өнгөрөгч баасан гарагт 85 дугаар зарлиг гаргаж, УИХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн Анхдугаар чуулганыг товлон зарлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг тус тус үндэслэн долоо дахь удаагийн сонгуулийн Анхдугаар чуулганыг энэ сарын 5-ны өдөр буюу мягмар гарагт 11.00 цагт товлон зарласан байна. УИХ-ын анхдугаар хуралдаанаар УИХ-ын дарга болон дэд дарга нарыг томилох, мөн нам эвслийн бүлгүүд байгуулах учиртай. Тэгвэл МАН-ын зүгээс УИХ-ын даргаар хэнийг томилох вэ гэдэг асуудлыг ярьж эхэлсэн байна. Эх сурвалжуудын өгч буй мэдээллээр УИХ-ын даргаар намаа ялалтад хүргэсэн М.Энхболд суух нь гэх мэдээлэл байгаа юм. Хэдийгээр ялсан намын дарга Ерөнхий сайд хийх учиртай ч М.Энхболд дарга ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгуульд намаа төлөөлж өрсөлдөнө гэх мэдээлэл байна.

Мөн энэ суудалд УИХ-ын гишүүн Н.Энхболд сууна гэх яриа ч гараад буй. МАН-ын хувьд боловсон хүчний нөөц сайтай гэдгээрээ бусад намаас ялгардаг. Тухайлбал, УИХ-ын гишүүн Ц.Нямдорж ч УИХ-ын дарга хийж байсан туршлагатай нэгэн билээ. Эдгээр гурван хүнээс нам шийдвэр гаргах нь ээ. Тэгвэл шинэ парламентын анхны хуралдааныг УИХ-ын гишүүн Ч.Улаан ахлах аж. УИХ-ын тухай хуульд хамгийн ахмад настай нь хуралдааныг даргална гэж заасан байдаг учраас Ц.Нямдорж, Д.Лүндээжанцан нараас гурван насаар ах Ч.Улаан хуралдааныг даргалах юм байна. Түүний хувьд 1954 онд төржээ. Харин Д.Лүндээжанцан гишүүн 1957 онд төржээ.

## ХОТЫН ШИНЭ ДАРГА СУ.БАТБОЛД ГЭЖ ХЭН БЭ

Б.ЭРХЭС

НИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит хуралдаан өнгөрөгч баасан гарагт болсон билээ. Энэхүү хуралдаанаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн долоо дахь удаагийн хурлын анхдугаар хуралдааныг өнөөдөр 11:00 цагт хуралдуулахаар товложээ. Хуралдаанаар Нийслэлийн ИТХ-ын сонгууль явуулсан дүн, бүрэн эрхийг зөвшөөрөх тухай, Нийслэлийн ИТХ-ын даргыг сонгох, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тоог тогтоож, Тэргүүлэгчдийг сонгох, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид нэр дэвшүүлэх тухай асуудлыг тус тус хэлэлцэхээр шийдвэрлэжээ. Дашрамд дурьдахад, сонгуулийн санал хураалтаар олонхи болсон МАН-ынхан өнгөрөгч баасан гарагт Удирдах зөвлөлөө хуралдуулж УИХ-ын гишүүн Су.Батболдыг хотын шинэ даргаар томилно гэсэн шийдвэр гаргасан юм. Мэдээж нийслэлд намаа удирдаж орсон гэдэг утгаараа ИТХ-ын гишүүн Д.Амарбаясгалан, Нийслэлийн МАН-ын дарга Ц.Сандуй нарын нэг нь Засаг даргаар очих учиртай ч эдгээр залуусын хувьд туршлагагүй гэж үзсэн бололтой.

Тиймээс УИХ-ын сонгуульд нэр дэвшихээс татгалзаж намынхаа сонгуулийн штабыг удирдаж оролцсон УИХ-ын гишүүн Су.Батболдыг нийслэлийн Засаг даргаар томилох шийдвэр гаргасан байна. Харин Д.Амарбаясгалан, Ц.Сандуй нарын нэг нь ИТХ-ын даргаар очих нь ээ. УИХ-ын гишүүн Су.Батболдын хувьд 1985 онд Төв аймгийн Зуунмод хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 1990 онд Хөдөө Аж Ахуйн Дээд Сургууль ХАА-н инженер мэргэжлээр,1995 онд Төрийн захиргаа, удирдлага хөгжлийн институтийг Удирдлагын арга зүйч, зохион байгуулагч менежер мэргэжлээр тус тус төгссөн. Техникийн ухааны магистр зэрэгтэй. Тэрбээр 1990-1993 онд Төв аймгийн Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны зөвлөлд инженер, 1993-1995 онд Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, хөдөө аж ахуйн хэлтэст ерөнхий инженер, 1995-1997 онд Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, хөдөө аж ахуйн хэлтсийн дарга, 1997-1998 онд Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн орлогч дарга, 1998-2000 онд Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, 2000-2002 онд Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар тус тус ажиллаж байв. Мөн 2002 онд УИХ-ын гишүүнээр сонгогдсоноос хойш УИХ-д тасралтгүй дөрвөн удаа Төв аймгаас нэр дэвшин, сонгогдож байна. Энэ хугацаанд тэрбээр Хууль зүй, Дотоод хэргийн Яамны Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Даргаар ажиллаж байсан, залуу, туршлагатай түшээдийн нэг юм.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

## МАН-ынхаан хэлсэндээ хүрээрэй

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Тиймдээ ч Засгийн газраа эмхлэн байгуулах, хэн хэнийг сайдаар томилох вэ гэдгээ яриад эхэлчихсэн хэрэг л дээ. Ерөнхийлөгч ч ирэх сарын 1 гэхэд УИХ, Засгийн газар бүрдэх ёстой гэдгийг хатуу мэдэгдсэн. Хамгийн эхний асуудал бол ялсан намын дарга Ерөнхий сайд болдог гэх дүрмээрээ М.Энхболд Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайд болох нь тодорхой байгаа юм. Тэгвэл М.Энхболдын мэргэжлийн Засгийн газар 11 яамтай байхаас гадна сайд нарын марафон ч аль хэдийнэ эхэлчихсэн. Учир мэдэх хүмүүс МАН энэ удаагийн сонгуулиар залуусаа дэвшүүлж, лидерүүдээ үлдээсэн нь тэднийг Засгийн газарт ажиллуулна гэсэн таамагтай нийцэж байх шиг. Мөрийн хөтөлбөрт нь тусгаснаас харахад, Хууль зүйн яам, БОНХЯ, Сангийн яам, Гадаад хэргийн яам гэсэн дөрвөн яам “давхар дээл”-тэй сайдтай байх бололтой. Харин Шадар сайдад У.Хүрэлсүхийг томилох нь хамгийн боломжтой хувилбар хэмээн үзэж байгаа гэсэн. Түүнчлэн БСШУЯ-ны хувьд Ё.Отгонбаяр гэсэн таамаг байгаа бөгөөд Т.Ганди, Ж.Сауле, В.Удвал нар Засгийн газарт орж ирэх магадлал ч өндөр байгаа. Харин ЭМС-ын сайдаар Д.Очирбат, Хүнс, хөдөө аж, ахуй хөнгөн үйлдвэрийн сайдаар ажиллаж байсан Т.Бадамжунай, дэд сайд асан Ж.Цолмон гэх мэтчилэн таамаг гарчихаж. Үүнээс гадна яамдын тоог цөөлж, төрийн албыг цомхон болгох тухай яриа ч гараад байгаа билээ. Магадгүй яам нь цөөхөн болохоор сайд нар давхар дээлтэй болчих юм биш биз гэсэн хардлага ч одоо явж байна. Засгийн газрын 2014 оны шинэчлэгдсэн бүтцээр 13 яам, 11 тохируулагч агентлаг, 19 хэрэгжүүлэгч агентлагтай ажиллахаар болсон. Гэхдээ 16 сайдтай байх бөгөөд үүнээс хоёр нь Шадар сайд, нэг нь Ерөнхий сайд хэвээр байхаар тусгагдсан. Тэгвэл үүнийг өөрчлөх эрх МАН-д бий. Мэдээж УИХ-д сонгогдсон шинэ залуусыг юу юугүй сайд дарга болгохгүй нь ойлгомжтой биз. Тэгэхээр “хуучин бууны хугархай”-нуудад сайд даргын сэтэр буух нь дамжиггүй. За тэгээд, ямар ч таамаг өрнөж байсан МАН-ынхан одоо хэлсэн амандаа хүрч мэргэжлийн Засгийн газраа байгуулах ёстой. Тэгэхгүй бол парламентаар нь дүүрэн “бор халзан хонь”-нууд байгаа шүү дээ. УИХ-д сонгогдож, түр үнэмлэхээ гардаад буй МАН-ын гишүүдийн 39 нь “шинэков”-ууд. Тэд одоохондоо Төрийн ордондоо төөрч байгаа учраас энэ дөрвөн жилд суралцаад л дуусна. Тал хувь нь хууль баталж, улсыг удирдах учраас Засгийн газраа л олигтой байгуулахгүй бол хэцүүдэх биз. Тэгээд ч төв талбайд давхар дээл өмсч, эсэргүүцэл илэрхийлэн жүжиг тоглож явсан тэд ямар нүүрээрээ УИХ-аас сайд дарга томилох билээ. Эр хүн хэлсэндээ гэдэгчлэн мэргэжлийн болгохын тулд мөнгөнөөс татгалзахаас өөр аргагүй л болох нь дээ. Тэр тусмаа МАН-ынхан дэд сайдаас татгалзахгүй бол өнгөрсөн дөрвөн жилийнх нь тэмцэл үнэ цэнэгүй болж хувирна шүү дээ. Тиймээс эр хүн шиг хэлсэн ярьсандаа л байгаарай, МАН-ынхаан.




# АН-ЫН ЯЛАГДАЛД БҮГД БУРУУТАЙ

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ӨНӨРТОГТОХ

2012 онд олонхи бүрдүүлэх эрх авч, УИХ-ын танхимд мөнхөд суух аятай аашилж байсан АН-ынхан ялагдлын шокноосоо өнөөдрийг хүртэл гараагүй байна. Нөгөө талаар ардчиллын төлөө саналаа өгсөн хүн болгон амаа барин шогширч, маргаашийн ирээдүйдээ санаа зовниж эхэлжээ. Өнөөх л хүнд суртал, авлига, улсын төсвөөр угжуулж амьдардаг хязгааргүй эрх мэдэлтэй хүмүүс эргээд хотод цаашлаад улс орон даяар ноёлох болсонд харамсч байгаа нь илт. Ялагдлаа янз бүрийн шалтгаанаас эрж эхэллээ. Гудамжинд яваа жирийн иргэн ч хүртэл энэ ялагдалд итгэхгүй, хакердуулчихав уу, юу болов, яагаад хэмээн бие биеэсээ асууж буй нь худлаа биш. АН-ын жирийн гишүүдээс гадна лидер гэгдэх улстөрчид ч энэхүү ялагдалд өнөөдрийг хүртэл итгэхгүй явна. Арга ч үгүй. Тэд олонхи бүрдүүлэх эрх авч, хүчтэй сөрөг хүчинтэй, бас болоогүй бүлэг байгуулах хэмжээний гуравдагч хүчинтэй, бие даагчтай парламентыг бүрдүүлсэн ч хийж чаддаг, бүтээн байгуулалт хийдэг гэдгээ харуулсан. Сүүлийн 20 жил хийгдээгүй их бүтээн байгуулалт АН-ыг эрх барьж байх үед хийгдэж, нийслэл хот маань нүүрээ угаасан юм шиг өөрчлөгдсөн. Үүнийг хэн ч үгүйсгэхгүй. Гэвч юуны учир, яагаад тэд МАН-аас нэр дэвшсэн бор халзан хониноос ч долоон дор үнэлэгдэх болов. Үүнд олон шалтгаан бий. Бүтээн байгуулж, өөрчилж чадсан ардчилалдаа иргэд хатуурхах болсны бурууг тэд бусдаас биш өөрсдөөсөө эрэх учиртай юм. Энд хар машины буруу байхгүй. Саналаа 20 мянган төгрөгөөр худалдсан иргэд ч буруугүй. Өмнө нь ийм зүйл байсан, өнөөдөр ч амь бөхтэй оршсоор байгаа учраас ганцхан удаагийн сонгуулиар саналаа худалдчихсан мэтээр түйлшрах нь илүүц биз. “Царцааны нүүдэл” гарсан байлаа ч МАН-ыг 65 хүний санал авах хэмжээнд нөлөөлөх нь юу л бол. Тиймээс мөнгө тараасанд нь өгчихлөө. Хар машинд ямар нэг но орлоо, хакердчихлаа, ард түмний саналыг мөнгөөр худалдаад авчихлаа гэх мэтээр гоншигонож суухын хэрэг алга, АН-ынхаан. АН-ыг удирдаж байгаа З.Энхболд дарга, намаа хагалж бутаргаж байсан фракцийн нэг даргыг дангаар нь ялагдалдаа буруутгах шаардлагагүй юм. АН-ын ялагдалд хувь нэмрээ оруулсан хүмүүс бол УИХ-ын гишүүд нь бүгдээрээ. Намын аппаратыг сахиж суусан удирдлагын баг бүрэлдэхүүн ч энд буруутай. Доод дунд шатанд намаа удирдаж чадаагүй аймаг, дүүргийн АН-ын дарга нар ч буруутай. Төрийн ордондоо архи ууж суусан эмэгтэй улстөрчийн алдаа ч энд нөлөөлсөн. Бурхан тэнгэр, сүлд шүтээн ярьж түмний элэг доог болж байсан улстөрчийн нөлөө ч байлаа. Тавантолгойгоор талцаж хэрэлдсэн фракцийн дарга нарын зөрчил нөлөөлснийг үгүйсгэхгүй. Намаа зөв удирдаж чадаагүй, хэвлэл мэдээллийг үл тоосноороо АН-ын удирдлагуудын буруу ч бий. Хязгааргүй эрх мэдэлд хүрчихсэн аятай аашилж, нэг тойргийг өөрийн вант улс болгох шахсан нэр бүхий улстөрчийн оруулсан хувь нэмэр ч АН-ын үнэмшихэд хэцүүхэн ялагдалд жин дарна шүү. Гэрээ ч төвхнүүлж чадаагүй атлаа төр төвхнүүлнэ хэмээн дөвчигнөж, шинэчлэх тухай “буруу” ярьж гүйсэн залуусын алдааг ч үгүйсгэхгүй. Хамгийн аймшигтай нь ардчилагчид өөрөө өөрсдийгөө нухчин дарах гэж улайрч, өс хонзонгийн сэдлээр улс төр хийж байсныг хэн ч худлаа гэж хэлэхгүй билээ. АН-ынхан өнгөрсөн дөрвөн жилд бүгдээрээ л муухай байлаа. Төрийн суудалд очихдоо нэгнээ түлхэж унагадаг, сайдын суудлын төлөө үнэ цэнэ, үнэт зүйлээсээ урваж байсан бүхэн буруутай. Намынхаа доод, дунд шатанд ажиллаж чадахгүй намаа хоёр хувааж, эс бөгөөд эвдрэлцүүлж, хагалж байсан хүн бүхэн өөрийгөө ялагдалд буруутгах ёстой болов уу. Ардчилалд хайртай ард түмнийг Ардын намын нохой ч байсан дугуйлах хүртлээ гомдоосон хүмүүс АН нэрээр төрд суусан улстөрч бүхэн гэдгийг мартах учиргүй. Тиймээс дан ганц ард түмнийг буруутгаж, эс бөгөөс намынхаа хэдэн лидер улстөрчийг нүд үзүүрлэх шаардлагагүй гэж хэлэх гээд байна. Намыг удирдаж орсон гэдгээрээ З.Энхболд дарга болон түүний бүрдүүлсэн намын аппарат илүү хариуцлага үүрэх нь тодорхой асуудал. Тэд ч хариуцлагаа үүрнэ гэдгээ хэлчихсэн. Хариуцлага эрт эхэлж, шинэчлэл эрт хийгдэх тусмаа л АН-д сайнсан.

### Фракцийн улс төрөөс салахгүй л бол дахин ялалт ирэхгүй

Нэн тэргүүнд Ардчилсан нам дүрмээ шинэчилж, намынхаа аппаратад салхи оруулах цаг хэдийнэ болчихож. Үүнийг ч намын хүчтэй лидер улстөрчдөөс эхлээд жирийн гишүүд нь хүртэл яриад эхэлчихлээ. Түүнчлэн, энэ нам фракцийн улс төрөөс салахгүй бол цаашдаа ч ялагдал амсах нь тодорхой. Үндсэн дүрмээ шинэчилж, фракцийн улс төрөөс салсан цагтаа л АН-ынхан Ах намаа ялах нь тодорхой байгаа юм. МАН-ыг бодвол тэд харьцангүй шинэ улс төрийн хүчин. Монголын ард түмэн “намаа шинэчил” гэсэн том даалгавар өгч буй нь энэ удаагийн ялагдал байжээ гэдгийг хаа хаанаа ойлгож эхэлсэн нь сайшаалтай. Өвгөрсөн, үзэл бодлоо шинэчлээгүй намд ямархуу хүнд цохилт ирдэг вэ гэдгийг МАН-ын 2012 оны ялагдал харуулсан учраас АН-ынхан шинэчлэлийг цаг алдахгүй хийх тусмаа сайн. Залуухан улс төрийн хүчинд энэ удаагийн ялагдал олон зүйлийг ойлгуулах нь дамжиггүй. Ялагдлыг улс төр судлаачид олон янзаар тайлбарлаж буй. Тогтворгүй байдал буюу Засгийн газраа унагасан нь хот, хөдөөгүй ялагдахад хүргэсэн гэх тайлбарыг өгч байгаа аж. Засгийн эрхэнд гарчихаад төрөөр тоглохоос өөрийг хийдэггүй, өөрөөр хэлбэл засаглаж чаддаггүй гэдэг имижийг АН-ынхан бий болгосон ч худлаа биш. Нөгөө талаас УИХ-ын Сонгуулийн хуулийг өөрчилж жижиг можаритор болгох шийдвэр нь ялагдал хүлээх хамгийн том шалтгаан болсныг судлаачид дуу нэгтэй хүлээн зөвшөөрч эхэлжээ. Өөрөөр хэлбэл, стратегийн буруу тооцоолол ялагдал амсахад хүргэжээ. Жижиг мажоритар систем бол маш их савлагаа үүсгэдэг, сонгогчдын саналын багагүй хувь гээгддэг болохыг өмнө нь нэг удаагийн ялагдлаар амссан атлаа тэд хашралгүй дахиад өөрчилж үүнийгээ үр дүнг том жижиггүй хүртэцгээлээ. 2000 оны сонгуулийн дүнгээс сургамж аваагүй, сонгууль болохоос хэдхэн хоногийн өмнө хууль өөрчилснөөрөө тэд ялагджээ. АН-ын нэр хүнд унасан байлаа ч хэрвээ холимог тогтолцоогоор явсан бол ядахдаа 20 гаруй суудал тэд авч, хүчтэй сөрөг хүчин болж чадах байсныг судалгаагаар тогтоожээ. Тиймээс ялагдлын хамгийн гол буруутан нь өдгөө намыг удирдаж буй удирдлагууд, хуулийг өөрчлүүлсэн улстөрчид гэдэг нь тодорхой байгаа юм. Хуулийг өөрчилснөөр илүү олон суудал авна гэсэн буруу тооцооллоос үүдэж дөнгөж бүлэг байгуулж буй тус намын хувьд Ерөнхийлөгчийн сонгуулиар ямар тактиктай оролцох нь тун ч сонин байна. Цаашлаад намаа нэр хүндтэй, туршлагатай улстөрчид даатгаж, намаа бүрэн шинэчилж чадахгүй л бол 20 жил гудамжинд лааз өшиглөсөн түүхээ эргэж давтахгүй гэх баталгаа алга даа.

ӨӨР ӨНЦӨГ

# Э.БАТ-ҮҮЛИЙГ ХОТЫН ДАРГА БОЛГОЁ

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Энэ нь эрүүл мэндэд ч ашиг тусаа өгсөн гэж хэлж болно. Бүр дугаарын хязгаарлалтыг бид өөрсдөө хүсдэг болсон шүү дээ. Түүнчлэн утаа, хөрсний бохирдлоос салгах эхний алхам буюу Гэр хорооллын дахин төлөвлөлтийг эхлүүлснээр хаа сайгүй өндөр сайхан орон сууцнууд баригдаж, хашаагаа тохилог сууцаар сольсон иргэд эдүгээ тайван сайхан амьдарч байна. Тун удахгүй ийм сайхан орон сууцанд орно гэж баярлаж, хөөрч байсан хүмүүс олон бий. Арай ороогүй байгаа тэдний хүсэл мөрөөдөл талаар болж, өнөөх л гэр хороололдоо мөнхрөх вий дээ. Үүнээс гадна “Сайн хашаа” хэмээх хөтөлбөрийг эхлүүлсэн нь үнэхээр нүдээ олсон ажил байсан гэдгийг гэр хорооллын 180 гаруй мянган өрхийн иргэд хэлж байсан юм. Сантехникийн сайн шийдлийг хашаа руугаа татуулчихаад тохилог хаус хороолол болно, цаашлаад хотхон ч болж болох юм хэмээн ярьж байсан ах хүүгийн хүсэл мөрөөдөл зогсохгүй гэж найдах л үлдлээ. Төрийн үйлчилгээг бид түгжрэлгүй аваад сурчихжээ, аль хэдийнэ. Энэ бол төрийн үйлчилгээг түмэнд ойртуулсан Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийг байгуулсантай холбоотой.

> ...Түүн шиг сэтгэл зүтгэл гаргаж, хийх гэж зүтгэдэг, хийсэн ажил нь нүдэнд харагдаж, гарт баригддаг дарга дахиад олдохгүй гэдэгт мөрийцөхөд ч бэлэн байна. Нийслэлчүүдийн бараг 90 хувь нь Бат-Үүлийг дахин хотын дарга болгох хүсэлтэй байсан гэдэгт эргэлзэхгүй байна...

Хэдэн сар жилээр хүлээж, ууртай дарга нарыг тойглож, хаанаасаа хаалгач гэгдэн хараал урсгадаг байсан тэр цаг мартагдсан дууль болчихсон байсан юм. Харин одоо хуучин хэвэндээ орж, албан тушаалын наймаагаар орж ирсэн хүмүүсийг царайчлахгүй байгаа. Элэг бөөр авчих шахсан энхэл донхолтой замууд, эр зоригийн уулзварууд, зуслангийн замууд энэ дөрвөн жилд ямар сайхан боллоо доо. Хэлэх юм биш. Үүнийг манай нийслэлчүүд сайн мэдэж байгаа. За тэгээд, тоочоод байвал цаг цаас хүрэлцэхгүй их ажлыг дөрөвхөн жилийн дотор хийж амжуулсан шүү дээ, Үүл дарга. Өмнөх дөрвөн Засаг даргын санаа ч үгүй ажлыг өнгөрсөн дөрөвхөн жилийн дотор амжуулсан, тэр. Харин сая сонгуулийн дүн үнэхээр харамсмаар гарлаа. УИХ-д бол яах вэ гэхсэн. АН-ын дөрвөн жилийн хэрүүл, дарангуйлал, ихэрхэл бардамнал өөрсдийг нь тонгорсон нь тодорхой. Харин нийслэлчүүд хараалган болчихоогүй баймаар. Ажил хийсэн хүнийг ам хэлээ билүүдсэн хүнтэй андуурчихав уу, эсвэл. Өнгөрсөн дөрвөн жил анх удаа хот шиг хотод амьдарч үзсэн болохоор Үүл даргыг унасанд үнэхээр их харамсч байна. Өнөөдөр хүн бүр л харамсч байна. Түүн шиг сэтгэл зүтгэл гаргаж, хийх гэж зүтгэдэг, хийсэн ажил нь нүдэнд харагдаж, гарт баригддаг дарга дахиад олдохгүй гэдэгт мөрийцөхөд ч бэлэн байна. Нийслэлчүүдийн бараг 90 хувь нь Бат-Үүлийг дахин хотын дарга болгох хүсэлтэй байсан гэдэгт эргэлзэхгүй байна. Саяхан Налайх, Багануур хот захирагчаа өөрсдөө л сонгосон. Тэгвэл нийслэлчүүд бид ч гэсэн ирэх дөрвөн жил хэнийг хотын дарга болгохоо өөрсдөө шийдмээр байна. НИТХ-д сонгогдсон 45 хүн нийслэлийн 1.5 сая иргэнийг бүрэн төлөөлж чадахгүй. Тиймээс л “ХОТЫН ДАРГА”-ыг НИТХ биш нийслэлчүүд нь сонгодог болмоор байна. Э.Бат-Үүлийг хотын дарга болгоё.

Business Development

Rostec

## ОХУ-ЫН РОСТЕХ КОРПОРАЦИЙН ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭНИЙ ОРЧУУЛГА

# ОХУ-ЫН РОСТЕХ КОМПАНИ ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК БОЛОН МОНГОЛРОСЦВЕТМЕТ ХХК-ИЙН 49 ХУВИА ХУДАЛДАВ

Ростех болон Монголын Зэс Корпораци ХХК-иуд 2016 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Орос-Монголын хамтарсан хоёр уул уурхайн компани (Эрдэнэт үйлдвэр ХХК болон Монголросцветмет ХХК)-иуд дахь Ростехийн эзэмшлийн 49 хувийн хувьцааг Монголын Зэс Корпораци ХХК-д худалдах гэрээнд гарын үсэг зурав.

Хэлцэл нь бүрэн дуусгавар болж Ростех төлбөрөө хүлээн авлаа.

Энэхүү хэлцэл нь Монгол-Оросын талуудын эрх ашигт бүрэн нийцтэй байхын зэрэгцээ зах зээлийн нөхцөлд суурилсан байна. Уг хэлцлийг хийхийн тулд хоёр компанийн 49 хувийг төлөөлөх хувьцааг зах зээлийн нөхцөл байдал, компаниудын хөрөнгийн чанар, цаашид хөгжүүлэх боломж зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр үнэлжээ. Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний гол нөхцөлд олон улсын аудит, зөвлөхүүд хөндлөнгийн үнэлгээ өгсөн байна.

Улс төрийн хувьд Эрдэнэт үйлдвэр ХХК болон Монголросцветмет ХХК дахь Оросын талын хувьцааг Монголын зэс корпораци ХХК-д худалдах ажиллагааны талаар ОХУ-ын Засгийн газар болон Монгол улсын Засгийн газрын холбогдох шийдвэрүүд гарсан бөгөөд корпорацийн түвшинд Ростехийн удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн шийдвэрүүд тус тус гарсан болно. Хэлцэл нь Орос-Монголын эдийн засгийн хамтын ажиллагаар цаашид хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтойн зэрэгцээ хоёр орны улстөрийн харилцааг улам илүү батжуулах нэгэн хөшүүрэг болох юм.

Ростехийн хувьд дээрхи компаниуд (Эрдэнэт үйлдвэр ХХК болон Монголросцветмет ХХК) дахь өөрийн эзэмшлийн 49 хувийг худалдан мөнгөжүүлэх шийдвэр нь корпорацийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх болон 2025 он хүртэлх корпорацийн хөгжлийн стратегийн хүрээнд хэрэгжүүлэх хэд хэдэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг төвлөрүүлэхэд оршино.

Монголын Зэс Корпораци ХХК-ийн зөвлөхөөр олон улсын Скадден хууль зүйн фирм ажилласан бол Ростехийн хуулийн зөвлөхөөр Бэйкер энд М тус тус ажиллажээ.

Ростехийн Ерөнхий захирал Сергей Чемезов: "Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг худалдах хэлцлийн гол суурь нь бид өөрийн уул уурхайн компаниудыг зөв удирдах, Ростехийн стратеги, төлөвлөлтөнд нийцүүлэн өөр төрлийн хөрөнгөнд тохирсон менежментийг хэрэгжүүлэх юм. Эрдэнэт үйлдвэр ХХК болон Монголросцветмет ХХК-ийн 49 хувийг худалдсан нь өнөөгийн нөхцөлд хийсэн Ростехийн хамгийн том хэлцэл бөгөөд үүний дүнд манай компанийн төсөвт нэг дор хамгийн их бэлэн мөнгө орж ирсэн тохиолдол болов. Уул уурхайн компаниудын хувьцааг 100 хувь авснаар Монголын тал дээрхи компаниудыг цаашид өөрсдийн корпорацийн стратегийн дагуу хөгжүүлэх боломж бүрдлээ. Бид энэхүү хэлцэл нь цаашид Монголын эдийн засагт хөрөнгө оруулалт хийх шинэ боломжуудыг нээсэн үйлдэл бөгөөд хоёр орны улс төрийн хамтын ажиллагааг илүү батжуулна гэдэгт бүрэн итгэлтэй байна. Ростех нь цаашид Монголын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, литиум олборлолт, тээвэр ложистик болон бусад дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийж, өөрийн байр сууриа өргөжүүлэхэд бэлэн байна.

Манай корпорацийн менежментийн бодлогын дагуу уг хоёр компанийн 49 хувийг удирдах ажлыг Ростех Бизнес Девелопмент хариуцан гүйцэтгэдэг байсан. Ростех Бизнес Девелопмент компани нь Эрдэнэт үйлдвэр болон Монголросцветметийн хувьцаа эзэмшигчийн хувиар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд өртөг, зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, менежментийн зардлыг зөв хуваарилах болон компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх зэрэг хямралын эсрэг чиглэсэн олон арга хэмжээг авсан билээ" хэмээн тэмдэглэв.

РТ Бизнес Хөгжил ХХК-ийн Гүйцэтгэх захирал Андрей Коробовын цохон тэмдэглэснээр "Ростех болон Монголын зэс корпорацийн хооронд зурсан гэрээ нь Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ХХК-ийн хувьцааны үнэ цэнийг тогтоогоод зогсохгүй, Оросын талын хувьцаа эзэмшигч Ростехийн хөрөнгийг зах зээлийн түвшинд нийцүүлэн мөнгөжүүлсэн томоохон жишээ болов. Уг компаниудын санхүү, аж үйлдвэрийн чадавхийг сайжруулах зорилгоор РТ Бизнес Хөгжил ХХК-ийн санаачлан боловсруулсан стратеги, цогц арга хэмжээнүүд нь хувьцааг хоёр талын эрх ашигт нийцсэн нөхцлийн дагуу худалдах боломжийг бүрдүүлсэн. Түүнээс гадна энэ хэлцэл нь аливаа хөрөнгийг зөв зохистой удирдаж хувьцаа эзэмшигчийн үр ашгийг нэмэгдүүлэх ажиллагааны жишээ болсны зэрэгцээ бусад олон салбарт аливаа хөрөнгийг худалдах, хувьчлахаас өмнө хэрэгжүүлж үнэ цэнийг нэмэгдүүлж болох арга хэмжээ болсныг тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү моделийг бусад хөрөнгүүдэд мөн ашиглаж болох бөгөөд ингэснээр корпораци нь өөрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, хөтөлбөртөө санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх боломжийг олгох юм".

**"Ростех улсын корпораци"** нь иргэний болон цэргийн зориулалтаар өндөр технологи, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, үйлдвэрлэх, экспортлох зорилгоор анх 2007 онд байгуулагдсан. Тус корпораци нь нийт 663 аж ахуйн нэгжүүдээс бүрддэг. Тэдгээрийн 9 компани нь толгой компанийн хувиар цэрэг, аж үйлдвэрийн салбарт ажиллаж байгаа бөгөөд 6 компани нь иргэний зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарт үйл ажиллагаа явуулдаг бол 32 компани Ростехийн шууд удирдлагад байдаг. Ростехийн мэдлийн олны танил болсон брендүүдэд Автоваз, Камаз, Оросын Нисдэг тэрэг, VSM-PO-AVISMA багтана. Ростехийн салбар компаниуд ОХУ-ын 60 бүс нутагт үйл ажиллагаагаа явуулж, 70 гаруй орон руу бүтээгдэхүүнээ экспортлож байна.

**"РТ Бизнес хөгжил" ХХК** нь санхүү, аж үйлдвэрийн компани, төслүүдийг удирдан явуулахаар 2014 онд Ростехээс байгуулсан тусгай компани юм. РТ Бизнес хөгжил ХХК-ийг байгуулах гол шалтгаан нь Ростехийн гол үр ашигтай салбарт ажиллаж байгаа компаниудыг мэргэжлийн хөрөнгийн удирдлагаар хангах, олон төрлийн санхүүгийн хэрэгслийг ашиглах байв. РТ Бизнес хөгжил ХХК нь голлон инноваци, өндөр технологи (харилцаа холбоо, электроник, мэдээллийн технологи болон бусад аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл) болон бусад уламжлалт салбарт (ашигт малтмал, тээвэр ложистик, дэд бүтэц) ажилладаг. РТ Бизнес хөгжил ХХК нь РТ Глобал Ресурсис ХХК-ийн 100 хувийн хувьцааг эзэмшдэг бол Ростех нь РТ Бизнес хөгжил ХХК-ийн 100% хувьцааг тус тус эзэмшдэг.

**"Монголын Зэс Корпораци" ХХК** нь Монгол Улсын дотоодын 100 хувийн хөрөнгө оруулалттай компани юм.

**"Эрдэнэт үйлдвэр" ХХК** нь анх 1978 онд хоёр орны засгийн газрын хэлэлцээрээр байгуулагдсан. Эрдэнэт үйлдвэр нь Ази тив дэх хамгийн том зэс, молибдени олборлох, боловсруулах үйлдвэр бөгөөд жилдээ 26 сая тонн хүдэр боловсруулж 530,000 тонн зэсийн баяжмал, 4,500 орчим тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг.

**"Монголросцветмет" ХХК** нь анх 1973 онд хоёр орны засгийн газрын хэлэлцээрээр байгуулагдсан. Тус компани нь Бор-Өндөр сумын (12,000 орчим хүн амтай) гол аж ахуйн нэгж бөгөөд жонш, алт, төмрийн хүдэр олборлож, боловсруулах үйл ажиллагаа явуулдаг.

2016 он

# ДЭЛХИЙ

## Родриго Дютерт тангараг өргөснөөс хойш 10 гэмт хэрэгтэн амиа алджээ

Филиппиний шинэхэн Ерөнхийлөгч Родриго Дютерт тангараг өргөж, албан тушаалдаа томилогдоод ердөө дөрөв хоног буй. Тэгвэл түүнийг Ерөнхийлөгчийн тангарагаа өргөснөөс хойш хар тамхины хэрэгт сэжиглэгдсэн 10 хүн цагдаад буудуулж амиа алдсан байна. 71 настай Родриго Дютерт өмнө нь Давао хотын захирагчаар ажиллаж байхдаа гэмт хэрэгтнүүдтэй тууштай тэмцэж, "шийтгэгч" гэх хочийг хүртсэн байдаг. Харин өнгөрөгч тавдугаар сард болсон сонгуульд ялалт байгуулсныхаа дараа тэрбээр гэмт хэрэгтнүүдтэй хатуу тэмцэхээ амласан. Юун түрүүнд аюулгүйн албаны хүүль тогтоомжид өөрчлөлт оруулан цаазын ялыг сэргээнэ гэж мэдэгдсэн удаатай. Үүнээс гадна гэмт хэрэгтнүүд эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд галт зэвсэг ашиглах эрхийг цагдаагийн байгууллагад өгч, хар тамхины наймаачдыг хөнөөсөн хүүлийн байгууллагынхныг шагнаж урамшуулдаг болох талаар үг унагаж, олны анхаарлыг татаж байсан юм. Түүнчлэн, насанд хүрээгүй хүүхдүүдийг шөнийн цагаар гадуур явах болон 00.00 цагаас хойш архи согтууруулах ундаа зарж борлуулахыг хориглох зэрэг арга хэмжээ авна хэмээн ярьж байв. Тэгвэл Дютертийг Ерөнхийлөгчийн тангарагаа өргөснөөс хойш Булакон мужийн цагдаагийн алба хаагчид хар тамхины нууц бүлэглэлүүдтэй тэмцэх кампанит ажлаа эхлүүлж, эдүгээ хүртэл 10 гэмт хэрэгтнийг хөнөөсөн байна. Мөн Думагете хотын цагдаагийн байгууллага хар тамхи нууцаар тээвэрлэсэн хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийн гэрт нэгжлэг хийх үед эсэргүүцэл үзүүлсэн сэжигтэн ч мөн цагдаа нарт буудуулж амиа алджээ.



## Бангладешийн "ХАР БААСАН ГАРАГ"

Б.ДАВААХҮҮ

Бангладешийн нийслэл Дака хот дахь нэгэн кафег зэвсэгт этгээдүүд өнгөрөгч баасан гарагийн 21.00 цагийн үед барьцаалсан хэрэг гарсан. Гэмт этгээдүүд кафег барьцаалж, хяналтаа тогтоосны дараа тус улсын хэдэн зуун цагдаагийн бие бүрэлдэхүүн кафены барилгыг 10 цагийн турш бүсэлсний эцэст дайралт хийж, тухайн хэсэгт нэг хэсэгтээ буун дуу нүргэлж буй тухай орон нутгийн эх сурвалжууд дамжуулж байлаа. Энэхүү ширүүн буудалцааны үеэр цагдаагийн хоёр офицер амиа алдаж, 30 гаруй алба хаагч гэмтэж бэртсэн. Мөн өөрсдийгөө хэт даврагчид гэж нэрлэсэн гэмт этгээдүүд барьцаанд байсан 20 гаруй хүнийг хөнөөсөн гэдгээ мэдэгдэж байв. Гэвч ширүүн буудалцааны дараа кафе барьцаалсан этгээдүүдийн зургааг нь буудаж, нэгийг нь баривчилж аюулгүй болгосны дараа кафегаас гэм зэмгүй 20 хүний цогцсыг гаргажээ. Тэд бүгд гадаадын иргэд байсан аж. Хохирогчдын ихэнх нь буудалцаан эхлэхээс өмнө хүйтэн мэсээр зэрэмдэглүүлж нас барсан байдалтайгаар олдсон байна. Түүнчлэн цагдаагийн байгууллага аль улсын иргэд байсныг нууцалж байсан юм.

Харин тус улсын цэргийн генерал Шахаб Уддин "Франц пресс" агентлагт өгсөн ярилцлагадаа "Амиа алдсан 20 хүн бүгд гадаадын иргэд байсан. Ихэнх нь итали, япон хүн байсан" гэж ярьжээ. Үүнээс гадна хуулийнхан барьцааны хэргийн үеэр нийтдээ 13 хүнийг сулласан бөгөөд тэдний гурав нь гадаадын иргэн байсан гэсэн мэдээлэл байгаа юм. Тэдгээр гурван гадаадын иргэний нэг нь япон, хоёр нь Шри Ланка улсын иргэн байжээ. Нийтдээ иж бүрэн зэвсэглэсэн долоон гэмт этгээд гадаадын иргэд олноороо үйлчлүүлэх кафег онилж халдлага үйлдсэн байх бөгөөд тэдний зургаа нь бямба гарагийн өглөө болсон буудалцааны үеэр амь үрэгдэж, нэг нь амьдаараа баривчлагдсан байна. Хэргийн хариуцлагыг хэт даврагч "Лалын улс" бүлэглэл өөртөө хүлээгээд байгаа. Тиймээс үүнтэй холбогдуулан Бангладешийн Ерөнхий сайд Шейх Хасина Важед мэдэгдэл хийсэн бөгөөд тэрхүү мэдэгдэлдээ "Мусульман бол энх тайван, амар амгалангийн шашин. Шашны нэрийн дор үйлдэж буй үйлдэл утгагүй аллагаа зогсоо" хэмээн онцлон тэмдэглэжээ.

### Хохирогчид хэн байв

Цагдаагийн байгууллага хэдийгээр хохирогчдын хэн болох талаар тодорхой мэдээлээгүй ч, "Би Би Си" зэрэг томоохон хэвлэл мэдээллийн байгууллагууд хохирогчид чухам хэн байсан талаарх мэдээллийг хүргэсээр байна. Тодруулбал, гэмт хэрэгтнүүдийн гарт маш хэрцгийгээр амиа алдсан гадаадын 20 жуулчны ес нь итали хүмүүс байжээ. Бангладеш дахь Италийн Элчин сайдын яамнаас мэдээлснээр Кристиан Росси, Марко Тондат, Надиа Бенедетти, Адель Пуглиси, Симона Монти, Клаудиа Мария Д'Антона, Винсензо Д'Аллестро, Мария Риволи, Клаудио Каппелли нарын хүмүүс байжээ. Харин Японы долоон иргэн кафед байсан гэдгийг Элчин сайдын яамнаас өгч буй бөгөөд тэдний тав нь эрэгтэй, хоёр нь эмэгтэй байжээ. Одоогоор дөрвийнх нь нэр тодорхой болоод байна. Тодруулбал, Коёо Огасовара, Макото Окамура, Юко Сакай, Руи Шимодайра нар байжээ. Харин Бангладешийн хоёр иргэн байсны нэг нь Фараaз Аяааз Хоссай, мөн АНУ-ын Эмори их сургуулийн оюутан Ишрат Ахонд нар байсан аж. Мөн Эмори их сургуулийн оюутан АНУ-ын иргэншилтэй Абинта Кабир мөн тэнд байжээ. Түүнчлэн Энэтхэгийн 18 настай Калифорни их сургуулийн оюутан Тариши Жэйн ч кафед үдийн зоог барихаар очоод ийнхүү амиа алдсан байна.

## Хиллари Клинтон мэдүүлэг өгчээ

АНУ-ын холбооны мөрдөх товчоо тус улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаар нэр дэвшиж буй Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтоны хувийн имэйл хаягтай холбоотой асуудлаар мэдүүлэг авчээ. Клинтоны ойрын эх сурвалжийн мэдээлснээр АНУ-ын нийслэл Вашингтон ДС хотын Холбооны мөрдөх товчооны төв байранд ойролцоогоор гурван цаг гаруйн хугацаанд байцаалт өгсөн аж. Үүнээс өмнө Хума Абедин нарын хүмүүс ч гэсэн байцаалт өгөөд байсан юм. Хиллари Клинтоны төлөөлөгч Ник Меррилл мэдэгдэлдээ "Хиллари Клинтон өнөөдөр өглөө Төрийн нарийн бичгийн дарга байх үеийн емэйлтэй холбоотойгоор сайн дураараа байцаалт өгсөн. Түүний хувьд хууль хяналтын байгууллагатай энэ хэрэгт хамтран ажиллаж үнэн зөвийг нь тогтоохдоо баяртай байгаа. Хэрэг мөрдөн байцаалтын шатандаа яваа учир байцаалтын талаар ямар нэг мэдээлэл өгөхийг тэр хүсээгүй" хэмээн ярьсан байна. Ник Мерриллын хувьд сайн дураараа гэдэг үгийг тодотгож байсан бөгөөд Холбооны мөрдөх товчооноос ямар нэг мэдэгдэл хүсэлт Хиллари Клинтонд ирээгүй гэдгийг онцолсон байна. АНУ-ын анхны эмэгтэй Ерөнхийлөгч болох магадлал тун өндөр байгаа Хиллари өмнө нь 2009-2013 онуудад Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан бөгөөд тухайн үед хувийн имэйл хаяг, сервэрээ төрийн ажилд ашиглаж байснаараа төлөө уучлалт гуйсан байдаг.

## Лондонд жагсаал болж байна

Их Британийн нийслэл Лондон хотын төв хэсэгт эсэргүүцлийн жагсаал зохион байгуулагдлаа. Зохион байгуулагчдын мэдээлж буйгаар уг жагсаалд 40 гаруй мянган хүн оролцож буй бөгөөд тэд өнгөрсөн сарын 23-ний өдөр болсон бүх нийтийн санал асуулгын үр дүнг эсэргүүцэж байгаа ажээ. Жагсаалд оролцогсод Европын холбооны далбааг барьж, "Бид Европын холбоонд хайртай" гэх зэргээр хашгирч, Конгрессийн ордоны өмнөх талбай хүртэл жагсч байна. Европын холбооноос Их Британи гарах эсэх талаарх бүх нийтийн санал асуулга өнгөрсөн сард болж, нийт иргэдийн ихэнх нь "гарах" гэсэн сонголт хийсэн юм. Улмаар үлдэх сонголт хийхийг ард иргэдээ уриалж байсан Ерөнхий сайд Дэвид Камерон ирэх аравдугаар сард огцорно гэдгээ мэдэгдсэн. Одоогоор түүний суудалд Консерватив намын таван хүн нэр дэвшиж байгаа билээ. Түүнчлэн, дахин бүх нийтийн санал асуулга явуулахыг шаардсан гарын үсэг цуглуулах ажиллагаа сошиал сүлжээнд тарж, хоёр сая гаруй хүн гарын үсгээ зурж нэгдсэн гэсэн мэдээлэл байгаа юм.

МЭДЭЭЛЭЛ

# КАЗАХСТАН ЕВРАЗИЙГ ХОЛБОСОН САНХҮҮГИЙН ТӨВТЭЙ БОЛНО

Х.БАТЖАРГАЛ



Казахстаны нийслэлд болох "Экспо-2017" дэлхийн үзэсгэлэн яармагийн дараа "Астана" хэмээх олон улсын санхүүгийн төв анхны үйлчлүүлэгчээ хүлээн авахад бэлэн болжээ. Барууны хөрөнгө оруулагчид тус төвд итгэл муутайгаар хандаж, оросууд "Астана"-г нэгэн шинэ оффшор бүс болж хувирах вий гэж болгоомжилж байгаа юм. Харин Казахстан улс өөрийн нутагтаа Евразийн санхүүгийн "боомт"-ын орон зайг бий болгох боломжтой хэмээн үзэж байна. Казахстаны зүгээс олон улсын санхүүгийн байгууллагыг Астанадтөвтэйгээр байгуулах үйл ажиллагааг хэдэн жилийн өмнөөс эхлэн санаачилж байсан.

"100 тодорхой алхам" нэртэйгээр хэрэгжүүлж эхлээд буй Ерөнхийлөгч Н.Назарбаевын төлөвлөгөөнд тус улсын эдийн засагт түлхэц авчирч улмаар улс төрийн болон нийгмийн хөгжлийг бий болгох боломж нөхцөл, үйл ажиллагааны явц дараалалыг тодорхой тусгаж өгчээ. "Астана" олон улсын санхүүгийн төвд орж буй компаниуд 50 жилийн турш хөрөнгө оруулалтын төслүүдэд ашиглагдах түүхий эд, материалыг оруулж ирэхэд тавьдаг нэмэгдсэн өртгийн албан татвар төлөхгүй аж. Мөн энд хөнгөлөлттэй нөхцөл, онцгой виз болон валютын журам дэглэм үйлчилнэ. Тус төвийн захирал Кайрат Касимбетовын хэлснээр, энэхүү санхүүгийн төвийн үйл ажиллагаанд буюу "Астана"-д Казахстаны хөрөнгийн биржийн худалдааг оруулж байршуулах ба мөн энэ төвд бүх төрийн компаниудын "IPO" бүртгэгдэх юм. Түүнчлэн тус төвөөр дамжуулан улсын сан хөмрөг болон хуримтлалын, тэтгэврийн нэгдсэн сангуудын активууд өөр өөрийн захиран зарцуулагчтайгаар ажиллах ажээ. Бас энэ санхүүгийн төвийн биржид исламын үнэт цаасны санг багтаах юм байна. Казахстан улсын ерөнхийлөгч Н.Назарбаев тус төвийн үйл ажиллагаатай танилцах явцад удирдах зөвлөлийн гишүүд нь "Астана" санхүүгийн төвийг бүхэлд нь 2016 оны төгсгөлөөр хөрөнгө оруулагчдад танилцуулах болно гэжээ. "Астана"-ийн удирдах зөвлөлийн гишүүдийн үзэж байгаагаар, санхүүгийн төвийн төлөвлөсөн бүх ажил, хууль зүйн журам ажлын нөхцөл бүрдүүлэлт хугацаандаа биелбэл энэ ондоо үйл ажиллагаа нь эхлэх ажээ. Одоогоор иймэрхүү хэлбэрийн үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн томоохон байгууллага евразийн бүс нутагт байхгүй юм. Төлөвлөгөө ёсоор бол энэхүү санхүүгийн төв нь Киргиз, Узбекистан, Тажикстан улсуудын зах зээлийн үйл ажиллагаанд үйлчилгээ үзүүлж, яваандаа Монгол болон Кавказын бүсэд нэвтрэх юм. Саяхан Санкт-Петербургийн эдийн засгийн форумын хүрээнд болсон оросын бизнес эрхлэгчидтэй уулзсан уулзалт дээр Нурсултан Назарбаев ОХУ-аас Казахстанд орох хөрөнгө оруулалтын хэмжээ буурсныг тэмдэглэж хэлээд "Астана"-ийн үйл ажиллагааны талбар дээр хамтарч ажиллахыг урьжээ.

Санхүүгийн гадаадын шинжээчид Казахстаны үндэсний мөнгөн тэмдэгт хэд хэдэн удаа дараагийн ханшийн уналтад өртөж, макро эдийн засгийн салбарын ханшны буурал үргэлжлэн улмаар Казахстаны бараан үнэ өртөг доошилж хөрөнгө оруулагч, болон үйл ажиллагаа эрхлэх компаниудад таатай боломж үүсгэж байгааг онцолжээ. Түүнчлэн тус улсад төрийн өмчийн томоохон компаниудыг хувьчлах үйл явц явагдаж байгааг тэмдэглэж байна.

Орон нутаг, бүсийн мөнгөн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгоор "Астана" олон улсын санхүүгийн нь дэлхийн тэргүүлэх түншүүдтэй хамтран өндөр технологийн биржийн дэд бүтцийг бий болгох ажил явуулж байгаа ажээ. Энэ чиглэлээр Лондонгийн Хөрөнгө санхүүгийн бирж, металл бүтээгдэхүүний бирж, NASDAQ, Чикаго хотын бараа бүтээгдэхүүний бирж, NASDAQ DUBAI, Нью-Йоркийн хөрөнгө санхүүгийн биржтэй ярих хэлэлцээрийг хийжээ. Шинжээчдийн үзэж байгаагаар бүс нутгийн болон орон нутгийн бизнесийнхнийг энэ үйл ажиллагаанд идэвхтэй хамруулах хэрэгтэй. Шинэ бизнесийн технологи нэвтэрснээр Казахстаны бизнесийнхэн чанартай санхүүгийн үйлчилгээ явуулах нөхцлийг бий болгож хөгжүүлэх боломж гарах юм.

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛД ГАЗАР ҮНЭГҮЙ БҮРТГЭНЭ

Н.БАТЗАЯА

*Эд хөрөнгийн эрхийн бүртгэлд хэрхэн бүртгүүлэх болон эрхийн бүртгэлтэйхолбоотой зарим зүйлийг УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга А.Туяагаас тодруууллаа.*

**-Эд хөрөнгийн бүртгэлийг хэд ангилдаг юм бэ. Эд хөрөнгийн бүртгэлийн талаар тайлбарлаж өгөхгүй юу?**

-Энэ бол эд хөрөнгийн бүртгэл биш. Эд хөрөнгийн эрхийн бүртгэл. Нэг үгээр хэлбэл, иргэнд Үндсэн хуулиар олгогдсон өмчлөх эрхийн дагуу тухайн иргэний өмчийг улсын бүртгэлээр дамжуулан баталгаажуулж байгаа юм. Тэгэхээр хөрөнгийн бүртгэл гэвэл хөрөнгийн тооллого шиг тоолж бүртгэнэ. Харин эрх гэдэг нь тухайн хүний өмчлөх, худалдах зэрэг Иргэний хуульд заасан бусад эрхийг хэлж байгаа юм. Тухайлбал, худалдах, борлуулах, барьцаалах, түрээслэх, ашиг олох зэрэг эрх бий. Энэ эрхүүдийг эд хөрөнгийн эрхийн бүртгэлд бүртгэдэг гэсэн үг.

**-Эд хөрөнгийн эрхийн бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүй гэж боддог хүмүүс байгаа байх. Эрхийн бүртгэл ямар давуу талтай юм бэ?**

-Эрхийн бүртгэлд бүртгүүлснээр иргэний өмчлөх эрх нь илүү баталгаатай болдог. Хэрвээ иргэн хөрөнгөө эрхийн улсын бүртгэлд бүртгүүлээгүй бол хөрөнгө нь зах зээлд эргэлтэнд орох боломжгүй болно. Манай улсад бүртгэлгүй хөрөнгийг худалдаж авдаггүй. Мөн бүртгүүлээгүй хөрөнгийг барьцаалах боломжгүй. Тэгэхээр барьцаа заавал улсын бүртгэлд бүртгэгдэж байж хүчин төгөлдөр болдог. Эрхийн бүртгэл байдаг учир нь гэвэл нэгдүгээрт, иргэнийхээ өмчлөх эрхийг улсын бүртгэлээр дамжуулан хамгаалж байгаа юм. Хоёрдугаарт, эдийн засгийн харилцааг эрсдэлгүй, илүү баталгаатай болгодог. Ийм ач холбогдолтой. Хэрвээ эрхийн бүртгэл байхгүй бол банкны барьцаа баталгаагүй болно. Би барьцааллаа гэсэн хэрнээ бүртгэлгүй байвал ямар ч баталгаа болж чадахгүй. Тиймээс эрхийн бүртгэл чухал. Дахин хэлье. Энэ бол эд хөрөнгийн бүртгэл биш юм. Эрхийн бүртгэлийн тухай хууль гэж байдаг. Иргэд ихэвчлэн эд хөрөнгөө эдийн засгийн харилцаанд орж, барьцаалах болохоороо л бүртгүүлдэг. Орон сууцыг худалдаж авахдаа бүртгүүлчихдэг юм. Харин иргэд газраа бүртгүүлдэггүй. Монгол Улсын иргэнд Газар өмчлүүлэх тухай хуулиар хашааны газар авахад газрын албанаас өмчлөх эрхийн гэрчилгээ өгдөг. Энэ бол газар өгсөн гэсэн зөвшөөрөл. Харин үүний дараа газраа улсын бүртгэлд заавал бүртгүүлэх хэрэгтэй. Ингэснээр тухайн иргэний өмч илүү баталгаатай болох юм. Тодорхой жишээ дурьдвал газар давхардах тохиолдол их гардаг. Ийм тохиолдолд өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлсэн хүнийх нь илүү баталгаатай гэсэн үг. Тухайлбал, бүртгүүлсэн бүртгүүлээгүй хоёр хүн байгаад газрын албан дээр давхардал гарлаа гэж бодъё. Ийм үед эрхийн бүртгэлд бүртгүүлсэн хүнийх нь газар илүү баталгаатай болно. Иргэд газраа эрхийн бүртгэлд бүртгүүлэх тал дээр төөрөгддөг. Өөрөөр хэлбэл, газрын албанаас өгсөн зөвшөөрөл л байхад хангалттай гэж боддог. Энэ нь буруу ойлголт. Эд хөрөнгөө эрхийн бүртгэлд бүртгүүлэх нь тухайн иргэний хөрөнгийг илүү баталгаатай, найдвартай болгодог гэж ойлгох хэрэгтэй.

**-Эрхийн бүртгэлийн гэрчилгээг хаяж, үрэгдүүлсэн тохиолдолд хэрхэн авах вэ?**

-Гэрчилгээгээ хаясан тохиолдолд харьяа аймаг, дүүргийнхээ эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хэлтэст өргөдөл болон нотлох баримтуудыг өгөх ёстой. Үүний дараа ерөнхий бүртгэгчийн шийдвэрээр дахин олгодог. Бүрдүүлэх материал гэвэл өдөр тутмын сонинд гэрчилгээгээ хаясан тухай зар тавих ёстой. Зар тавьсан сониныхоо эх хувийг авч ирнэ. Мөн үйлчилгээний хураамж 20 мянган төгрөг төлнө.

**-Хаясан гэрчилгээг хэд хоногийн дотор дахин олгодог юм бэ?**

-Гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд дахин олгохдоо улсын ерөнхий бүртгэгчийн шийдвэрээр мэдүүлэг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор олгоно.

**-Эрхийн бүртгэлд өөрчлөлт, залруулга оруулж болох уу?**

-Болно.Гэхдээөөрчлөлторуулах зүйл нь үнэн бодитой, нотлох баримттай байх ёстой.Тухайлбал, гэрчилгээн дээр байрны талбайг 60мкв гэж бичсэн хэдий ч бодит байдал дээр мэргэжлийн байгууллагаар хэмжүүлэхэд өөр байгаад, түүнийгээ нотлох баримттай байвал өөрчлөлт оруулж болно. Мөн хамтран өмчлөгчөө хасч эсвэл нэмж болдог. Хуулиар зөвшөөрөгдсөн өмчлөгчийн эрхийн дагуух бүх тохиолдолд өөрчлөлт орж байгаа. Бусадтай гэрээ хэлэлцээр хийх, барьцаалах, хүүхдээ хамтран өмчлөгчөөр авах, хамтран эзэмшигчээсээ татгалзах зэргийг өөрчилж болдог. Мөн захиргааны шийдвэрээр хаяг өөрчлөгдсөн тохиолдолд эрхийн бүртгэлийг өөрчилнө. Хамгийн гол нь эрхийн бүртгэлд орж байгаа өөрчлөлт нь хуулийн дагуу нотлох баримттай, үнэн зөв л байх хэрэгтэй. Үнэн зөв гэдэг нь нотлох баримт нь эрх бүхий этгээдийн гаргасан баримт байх ёстой гэсэн үг.

**-Эд хөрөнгийн барьцааны гэрээг улсын бүртгэлд яаж бүртгүүлэх вэ. Ямар материал бүрдүүлэх шаардлагатай вэ?**

-Хуульд зааснаар барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлж байж хүчин төгөлдөр болдог. Тэгэхээр өмчлөгч, барьцаалагч хоёр гэрээ хийнэ. Харин хийсэн гэрээ нь манай байгууллагад бүртгэгдсэнээр барьцаа нь хүчин төгөлдөр болно. Тодорхой үүрэг хүлээж, үүргээ барьцаагаар баталгаажуулсан гэдэг утгатай гэрээ хийн тодорхой хураамж төлж манай байгууллагаар баталгаажуулах ёстой. Барьцааны гүйцэтгэхэд үүргээ хүлээн зээлээ төлчихсөний дараа эсвэл барьцаагаар хангагдах ямар үүрэг хүлээсэн түүнийгээ биелүүлсэн тохиолдолд тухайн барьцаалагч энэ хүн үүргээ хүлээсэн гэдэг мэдэгдлээ манайд өгнө. Мэдэгдэл өгсөн тохиолдолд барьцааны эрх нь цуцлагдана. Манайд цуцлах бүртгэл хийнэ. Бүртгэгдсэн бүртгэлийг эргэж цуцалдаг. Тэгэхээр байраа барьцаанаас чөлөөлүүлнэ гэсэг үг.

**-Эрхийн бүртгэлд бүртгүүлэхэдтодорхойхураамж төлдөг үү. Төлдөг бол нэгдсэн хураамж авдаг уу. Эсвэл газар, орон сууц бүртгүүлэхэд өөр өөр хураамж авдаг уу?**

-Үйлчилгээ болгоны хураамж харилцан адилгүй. Гэхдээ иргэнд өмчлүүлсэн газрыг хураамжгүйгээр бүртгэж байгаа. Иргэний газар өмчлөх эрх, өмчилсөн газраа улсын бүртгэлд бүртгүүлэх боломжийг нь бүрдүүлж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл, үнэ төлбөргүйгээр мэдүүлэг, нотлох баримтыг авч бүртгэж байгаа. Бусад бүртгэлийг хийхдээ Засгийн газрын тогтоолоор батлагдсан хураамжийг авдаг. Анх удаа бүртгүүлэхэд Тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар үнийн дүнгийн 0.5 хувиар бодож тэмдэгтийн хураамж авч байгаа. Хураамжийн төлбөр үнэтэй биш. Тухайлбал, 5-20 мянган төгрөг байдаг. Мөн бид ТҮЦ машинаас лавлагаа олгодог. ТҮЦ машинаас мянган төгрөгөөр лавлагаанууд гарч байна. Тэгэхээр нэгдүгээрт, Тэмдэгтийн хураамжийн тухай хууль, хоёрдугаарт, Засгийн газрын тогтоолоор батлагдсан үйлчилгээний хураамжийг л авдаг.

**-Иргэд газраа хэр идэвхтэй бүртгүүлж байна вэ. Таны хэлснээр газраа барьцаалах үедээ л бүртгүүлдэг шиг байна?**

-Иргэд газраа эргэлтэд оруулах үедээ л улсын бүртгэлд бүртгүүлдэг. Тухайлбал, банкнаас газраа барьцаалж зээл авах үедээ эрхийн бүртгэлд зайлшгүй бүртгүүлэх ёстой юм байна гэдгийг мэддэг. Энэ тохиолдолд л зарим хүмүүс бүртгүүлж байна л даа. Ер нь иргэд газраа бүртгүүлэх тал дээр идэвх муу байдаг. Улаанбаатар хот дахь хашаа байшингууд манайд бүртгэлтэй. Харин орон нутагт дахь газруудын бүртгэл муу. Ялангуяа, эзэмших, ашиглах газруудын бүртгэл эдийн засгийн харилцаанд ороогүй л бол бүртгүүлэх нь хойрго байгаад байна. Үүнд эрх зүйн хувьд үүнд шинэчлэл хийх хэрэгтэй. Газрын алба нэг гэрчилгээ өгчихөөр иргэд өмчлөх гэрчилгээтэй болчихлоо гэж бодоод байгаа юм. Тэгэхээр газрын албанаас гэрчилгээ өгөөд дээр нь дахиад манайд бүртгээд байгаа юм шиг хуулийн давхардлууд байгаад байна. Яг үндсэндээ яаж явах ёстой вэ гэхээр Засаг даргын шийдвэр гарч, газрын албанаас кадастрын зураг гардаг. Үүний дараа Засаг дарга болон газрын албаны шийдвэрүүд манай байгууллагад ирэн эрхийн гэрчилгээг нь өгөх ёстой юм. Ер нь ийм нөхцөлөөр явахгүй бол бүртгэл давхцаж байна. Тиймээс Газрын тухай хуульд өөрчлөлт оруулж, хуулиа шинэчлэх хэрэгтэй.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ЭНЭ ДОЛОО ХОНОГТ 33-38 ГРАДУС ХҮРЧ ХАЛНА

Ойрын өдрүүдэд ихэнх нутгаар ялангуяа газар тариалангийн бүс нутгаар хална. Өнөөдөр төвийн аймгуудын зарим газраар, 5-7 нд зарим газраар түр зуурын дуу цахилгаантай бороо орно. Борооны өмнө салхи түр зуур ширүүснэ. Ихэнх нутгаар халж Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар шөнөдөө 9-14 градус, өдөртөө 22-27 градус, Их нууруудын хотгор, Орхон-Сэлэнгийн сав газар, говийн бүс нутаг болон Дорнод, Дарьгангын тал нутгаар шөнөдөө 18-23 градус, өдөртөө 33-38 градус, бусад нутгаар шөнөдөө 14-19 градус, өдөртөө 27-32 градус дулаан байна. Иймд ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс бага насны хүүхдүүд, өндөр настан, даралт өндөртэй хүн, жирэмсэн эмэгтэйчүүдийг өдрийн халуун наранд гарахгүй байх, мөн наршихаас сэргийлэхийг анхааруулаа.

## Нийтийн тээврийн автобусны үзэмжийг сайжруулахыг үүрэг болгов

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийншуурхайхуралдаан өнгөрсөн баасан гарагт боллоо. Шуурхай хуралдааны үеэр инженер хангамж нийтийн үйлчилгээний байгууллагууд мэдээлэл хийлээ. Борооны ус зайлуулах шугамын нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд далангийн 1021.08 метр куб лагийг цэвэрлэн тээвэрлэж, нийт 1436 шүүрт худаг, 89443 урт метр шугам, 1267 үзлэгийн худгийг засварлажээ. Түүнчлэн Нисэх, Яармагийн аюулгүйн тойргоос Чингисийн хүрээ жуулчны бааз руу салах уулзвар хүртэлх 3,3 км урт автозамын голын тусгаарлах зурвас газрыг зүлэгжүүлсэн бөгөөд цэцэгжүүлэх ажлыг хийж эхлээд байгаа ажээ. АСЕМ-ын тохижилт, хотын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд "Ач –Очир" ХХК, "Эс-Деволопмент" ХХК, "Вест Хилл" ХХК, иргэн Н.Баттулга, Л.Болорболд, Ус сувгийн удирдах газрын сургалтын төв, "Эфис" констракшн, "Моннис" групп, "MSM" ХХК, "Эм Ай Ти Ай Си" ХХК, "Монголиа Проперти Деволопмент" ХХК зэрэг 11 аж ахуйн нэгж байгууллага, 78 159 000 төгрөгийн өөрийн хөрөнгөөр барилгын хашаа, хайс хашлагаа засварлан будаж, зам талбайн тохижилтын ажлыг хийсэн аж.

Хурлын үеэр Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Б.Бадрал Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн хайс хашлагыг угаах, гол болон туслах замуудын тэмдэг тэмдэглэгээг хийж дуусгах, Төв цэнгэлдэх хүрээлэн, Чингисийн хүрээ, Хүй долоон худгийн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, гэр хороолол, орон сууцны доторх зэрлэг ургамлыг устгах ажлыг зохион байгуулахыг нийтийн үйлчилгээ, инженер хангамжийн байгууллагуудад үүрэг болгов. Мөн Үндэсний баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд нийтийн тээврийн автобусны гадна дотор талыг өнгө үзэмжийг сайжруулж, жолооч нарыг цагаан цамц хар зангиатай үйлчилгээнд гаргах хэрэгтэйг сануулсан юм.

## Зургаан настай хүүхэд нүүрсний амбаарт гал тавьжээ

Улаанбаатар хотын цагдаагийн газарт өнгөрсөн баасан гарагт "Чингэлтэй дүүргийн дэнжийн ... тоотод гал гарч байна" гэсэн мэдээлэл иржээ. Дуудлагын дагуу цагдаагийн алба хаагчид Нийслэлийн Онцгой байдлын газрын шинжээчидтэй хамтарч шалгахад зургаан настай хүүхэд гал тавьсан нь тогтоогдсон байна. Тодруулбал, тус тоотод оршин суугч 24 настай эрэгтэй Б-ийн нүүрсний амбаарыг зургаан настай О нь асаагуураар тоглож байгаад шатаажээ. Хэргийг Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэс шалгаж байгаа юм байна. Иймд цагдаагийн газраас бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхихгүй байхыг анхааруулаа.

## "АСЕМ-ын залуучуудын чуулган" 5 хоног үргэлжилнэ

АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтын дагалдах хурлуудын нэг болох "АСЕМ-ын залуучуудын чуулган"-ыг энэ долдугаар сарын 6-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдана. Тус чуулганы ерөнхий зохион байгуулагчаар Монголын Залуучуудын Холбоо ажиллаж байгаа бөгөөд ASEF буюу Ази, Европын сан, Гадаад хэргийн яам хамтран зохион байгуулж байгаа аж. Дөрвөн өдөр үргэлжлэх уг чуулганд АСЕМ-ын гишүүн орны 100 төлөөлөгч, Монголын шилдэг 50 залуу оролцохоор бүртгүүлжээ. Улаанбаатар хотноо зохион байгуулагдах энэ удаагийн Чуулганд оролцогчид нь АСЕМ-ын гурван тулгуур болох улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын асуудлаар хэлэлцэх юм байна. Түүнчлэн АСЕМ-ын гишүүн улсууд дипломат айлчлал хийхэд оюутан, залуусын төлөөллөөс оролцуулах, албан ёсны төлөөлөгчдийг дагалдуулах урлаг соёлын олон талт үйл ажиллагаа зохиогдохоор болжээ.

Энэхүү АСЕМ-ын Залуучуудын Чуулган нь АСЕМ-ын дээд түвшний уулзалтын өмнө болдог том хэмжээний залуучуудын хуралдаан бөгөөд их, дээд сургуулийн оюутнуудад хурлын талаар ойлголт өгөх, залуусын идэвх сонирхол, оролцоог нэмэгдүүлдгээрээ онцлогтой. Түүнчлэн залууст дипломат ёс, яриа хэлэлцээний талаар мэдлэг олгох, олон нийтийн өмнө ярих, багаар ажиллах, зөвшилцөлд хүрэх, манлайлах зэрэг чадвараа хөгжүүлэхэд нь туслах зорилготой юм байна. Чуулганы гол үр дүн нь оролцогчдын хэлэлцүүлгээс нэгтгэгдсэн асуудлуудыг Дээд түвшний уулзалтаас гарах баримт бичигт тусгуулахад чиглэгдэж байгаа аж. Дашрамд дуулгахад, уулзалтын бэлтгэл ажил, зохион байгуулалтын талаар маргааш 12:00 цагт зохион байгуулагч Монголын Залуучуудын Холбооноос мэдээлэл өгөхөөр болсон байна. Уг хэвлэлийн хурал АСЕМ-ын мэдээллийн төвд болох аж.

## Ослын улмаас хоёр хүн амиа алджээ

Улаанбаатар хотын Замын цагдаагийн газрын ЖШУХ-т энэ сарын 1-нд нийт 242 дуудлага мэдээ мэдээлэл хүлээн авснаас зам тээврийн ослын 190 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс зам тээврийн осолд өртсөн сургуулийн өмнөх насны хүүхэд нэг, сургуулийн насны хүүхэд нэг тохиолдол бүртгэгджээ. Тодруулбал, Сонгинохайрхан дүүргийн Баянхошууны зам, Хилчин хотхоны 12 дугаар байрны зүүн замд T.Prius маркийн автомашины жолооч Т нь байрныхаа гадаа тоглож байсан зургаан настай Д, гурван настай Э нарын хоёр хүүхдийг мөргөж гэмтээжээ. Мөн хөдөө орон нутгийн замд зам тээврийн ослын улмаас хоёр хүн амиа алдсан байна. Тухайлбал, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын гуравдугаар багт засмал зам дээр Hyundai Sonata-6 маркийн автомашины жолооч Б нь ачааны Hongyan маркийн автомашинтай мөргөлдөж жолооч Б, Э нарын хоёр хүн нас барсан ажээ.

## Хүчингүйд тооцов

-Батчулуун овогтой Алтангэрэл /РД:ГЮ92080314/-ийн жолооны үнэмлэх гээгдүүлсэн тул

-9011085090 Улсын бүртгэлийн дугаартай 2867818 регистрийн дугаартай Эвт тулга ХХК-ийн гэрчилгээ гээгдүүлсэн тул

- УБГ00507 дугаартай Эм Эс Ди ХХК-ийн тамга гээгдүүлсэн тул тус тус хүчингүйд тооцов

PHOTO NEWS



*Өмнөговь аймагт Монголын хамгийн өндөр усан оргилуур нээлтээ хийлээ. Энэхүү оргилуур нь 42 метрийн өндөртэй бөгөөд өнгө өнгийн гэрлээр чимэглэгдсэн байна. Монголын хамгийн өндөр усан оргилуур Өмнөговь аймаг дахь амьд мэт үлэг гүрвэлтэй соёл амралтын хүрээлэн буюу хүүхдийн паркад байрладаг ажээ.*

# ЗАВСАРЛАГА

ДУУЛГАХ СОНИН



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Чингисийн талбайд сонгодог урлагаар “АМЬСГАЛЛАА”

Б.ДАВАА

Сонгодог урлагийн "Best of classics" үдшийн цэнгүүн гурав дахь жилдээ амжилттай болж өндөрлөлөө. Уг сонгодог үдшийн цэнгүүнийг үзэхээр найман настай балчираас наян настай буурлууд хүртэл хүрэлцэн ирсэн харагдав. Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын уран бүтээлчид энэ жил Чингисийн нэрэмжит талбайд цугласан таван мянган үзэгчдэдээ зориулан дэлхийн болон Монголынхоо сонгодог урлагийн сор болсон 16 бүтээлүүдээс дээжлэн, үзэгчдийн сонорыг мялаасан юм. "Best of classics" сонгодог урлагийн гадаа талбайн концерт Ж.Росинийн “Хулгайч шаазгай” дуурийн удиртгалаар эхэлсэн бөгөөд Ж.Бизегийн “Кармен”, “Трубадур” дуурь болон П.Чайковскийн “Нойрссон гүнж”, “Хунт нуур”, Ж.Чулууны “Уран хас”, Л.Минкусын “Пахита” балет зэрэг бүтээлийг нэгэн тайзнаа толилуулдгаараа онцлог билээ. "Best of classics" сонгодог үдшийн төгсгөлд УДБЭТ-ын балетын гоцлол бүжигчин МУГЖ Ч.Ганчимэг, балетын гоцлоочА.Эрдэнэболд нар Л.Минкусын “Пахита” балетын гран-па хэсгийг бүжиж, уран бүтээлчид хүндэтгэл үзүүлснээр өндөрлөсөн юм. Энэ зуны задгай талбайн анхны томоохон "Best of classics" шоу Чингисийн нэрэмжит талбайд хоёр цагийн турш эгшиглэж, Нийслэлийн хотын иргэдийг нэгэн үдэш сонгодог урлагаар “амьсгалууллаа”.













Улаанбаатарт:

Маргааш

Өдөр 30
Шөнө 17

Нөгөөдөр

Өдөр 32
Шөнө 17

Өдрийн зурхай

**Зуны дунд хөх морь сарын Хоёр хар мэнгэтэй улаагчин гахай өдөр**



*Аргын тооллын 7 сарын 4, Сумъяа гараг. Билгийн тооллын битүүн, Хэрцгий охин одтой, улаагчин гахай өдөр. Өдрийн наран 5 цаг 01 минутад мандан, 20 цаг 49 минутад жаргана. Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, хараал, жатхыг буцаах, нялхасын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар ухах, худаг гаргах, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.*

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## МОНГОЛ УЛС 600 МЯНГАН ЕВРОГИЙН ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛЫГ ХҮЛЭЭЖ АВЛАА

Н.БАТЗАЯА




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Одоогоос гурван жилийн өмнө Монголын ашигт малтмалын салбарт ахиц, дэвшил авч ирсэн томоохон үйл явдал болж байсан билээ. Тодруулбал, 2013 оны дөрөвдүгээр сарын 9-нд манай улсын Ашигт малтмалын газар, Бүгд найрамдах Чех улсын геологийн албатай уг салбарт хамтран ажиллах гэрээ байгуулсан юм. Тус гэрээнийн дагуу Чех улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Ховд аймгийн “Мөнххайрхан”, “Зэрэг”, “Манхан” сумын нутгийг хамрах 1:50000-ны машстабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг зохион байгуулахаар болсон билээ. Тэгвэл энэ сарын 1-нд Чех улсын онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ивана Гроллова уг геологийн зураглалын үр дүнгийн тайланг Ашигт малтмалын газрын дарга Д.Үүрийнтуяад хүлээлгэн өглөө. Уулзалтын үеэр, Чех улсын онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ивана Гроллова “Монгол Улс нийт газар нутгийнхаа ашигт малтмалын ерөнхий зураглалыг бүгдийг нь нарийн судалж гаргаагүй байна. Зарим газруудад хэсэг, хэсгээр л судалсан. Чех геологичид олон жил Ашигт малтмалын газартай хамтарч ажиллалаа. Чех, Монголын геологичид хамтран тодорхой газар нутгуудад геологийн газрын зургийг хийж байсан. Манай Ховд аймгийн гурван сумыг хамарсан геологийн зураглал гаргах төсөл гурван жил үргэлжиллээ.

Энэ төсөл маань 600 мянган еврогийн санхүүжилтээр хийгдсэн. Гурван жилийн турш үргэлжилсэн төсөл дууссч, бид 1:50000-ны машстабын геологийн зураглалыг хүлээлгэн өгөөд байна. Бидний хамтын ажиллагаа зөвхөн энэ төслөөр хязгаарлагдахгүй. Цаашид олон төсөлд хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна” гэв. Манай улс газрын доорх баялаг ихтэй боловч, бүх газар нутгийг хамарсан геологийн зураглал байдаггүй байна. Мөн энэхүү зураглалыг хийхэд маш их хөрөнгө, санхүүжилт шаарддаг учраас гадаадын хөрөнгө оруулагчид зураглал гаргадаг аж. Гэвч зарим гадаадын хөрөнгө оруулагчид ашигт малтмалын хайгуул хийн илрүүлсэн тохиолдолд өөрсдөө ашигт малтмалын лицензийг нь авах сонирхолтой байдаг. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагчдын гаргасан геологийн зураглал тийм ч тодорхой биш байдаг ажээ. Тухайлбал, өмнө нь хэсэг хэсгээр хийж байсан газрын зураглалууд хэн нэгний захиалгаар хийсэн байдаг бөгөөд үнэн худлыг мэдэхэд хэцүү. Тиймээс манай улсын хувьд газрын доорх баялгийн нарийн зураглалыг гаргаж, хаана, ямар ашигт малтмал байгааг мэдэх нь чухал. Ингэснээр хувийн ашиг хонжоо хайсан гадаадын хөрөнгө оруулагчдаас ашигт малтмалаа хамгаалж чадна. Үүнд албан ёсны төрийн байгууллага энэ чиглэлд ажиллах шаардлагатай байгаа юм.

Тэгвэл Ховд аймгийн гурван сумыг хамарсан 1:50000 машстабын зураглалыг гаргах төсөл нь хэн нэгэн гадаадын хөрөнгө оруулагчдад биш Монгол Улсад ашигтай гэдгээрээ онцлогтой. Товчхон хэлэхэд, Монгол Улс нийт газар нутгийнхаа 40 хувийн геологийн зураглалыг хийлгэлээ. Манай улс Чех улстай 53 жилийн хамтын ажиллагаатай бөгөөд геологийн салбарт Олон улсын геологийн экспедицид нэгдсэн цагаас үр дүнтэй хамтран ажиллаж эхэлсэн түүхтэй. Хамтын ажиллагааны хүрээнд Чех улсын геологичид манай улс дахь ашигт малтмалын олон ордыг нээж, улсад хүлээлгэн өгчээ.

Тухайлбал, 1971-1975 онд Хэнтий аймгийн нутагт хүдрийн ордыг нээж, 1976 оноос Онгонхайрханы гянт болдын газар, Төв аймгийн Баянцагаан сумын нутагт "Чулуут цагаан дэл"-д жоншны эрэл хайгуулын ажлыг явуулсан гэдэг. Мөн тус улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэд хэдэн геологийн зураглалыг хийсэн байна. Тодруулбал, 1999-2002 онд Чех улсын Байгаль орчны яамтай хамтран Алтайн цаад говьд 35410 кв.км талбайд "Алтайн чанад дахь талбайн 1:200000-ны геологийн зураглал, геологийн судалгаа"-ны ажлыг хийсэн аж. Түүнчлэн Монгол Улс, БНЧУ-ын хооронд геологи, эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг АМГТХЭГ, БНЧУ-ын геологийн албаны хооронд Монгол Алтайн нурууны талбайд 1:50000-ны масштабын зураглалын ажил хийх асуудлаар 2003 оноос эхлэн харилцан санал солилцож эхэлжээ.

Үүний үр дүнд Чех улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар Говь-Алтай аймгийн Чандмань, Эрдэнэ, Баянхонгор аймгийн Баацагаан, Бууцагаан сумдын нутгийг хамарсан Затын нурууны 3625.8 км.кв талбайд 2004-2007 онд гүйцэтгэх геологийн 1:50000-ны машстабын зураглал, ерөнхий эрлийн ажлын төслийг хэрэгжүүлэхээр тохиролцсон байна. Энэ мэтчилэн манай улс Чех улстай геологийн салбарт хамтран ажиллаж иржээ. Судалгааны ажлын тайланг хүлээлгэж өгөх үеэр Ашигт малтмалын газрын дарга Д.Үүрийнтуяа Чех улсын Засгийн газарт талархсанаа илэрхийлээд “Геологийн зураглал гаргах нь маш чухал. Хөрсөн доорх нөөц баялагийн хуримтлал, хэтийн төлөв ямар байгааг мэдэж авч болдог. Цаашид энэ чиглэлд Чех улстай хамтарч ажиллана. Мөн бид Чех улстай ураны хайгуулын ажилд хамтарч ажиллах талаар ярилцлаа. Харин тайлантай хараахан танилцаагүй байна. Тайланг манай мэргэжлийн хүмүүс хүлээж авна” гэсэн юм. Ямартай ч төрийн байгууллагууд геологийн газрын зураглалыг гаргах тал дээр анхаарч ажиллах шаардлага байна.